

Нийцлийн аудитын тайлан

Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээ,
вакцинжуулалт болон Монгол мал үндэсний хөтөлбөрийн
хэрэгжилт



Хөтөлбөрийн төсөл арга хэмжээнүүд
удаашралтай хэрэгжиж байна

Агуулга

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгсийн жагсаалт	1
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	2
ҮАГ-ын Нийцлийн аудитын газар	Бүлэг 1	
Аудитын менежер Б.Алтанзул	Хөтөлбөрийн арга хэмжээнүүд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна	3
Ахлах аудитор Б.Болормаа	Хөтөлбөрийн хууль эрх зүйн таатай орчин бүрдээгүй байна	3
Аудитор Э.Уянга	Төсвийн хөрөнгийг ач холбогдол багатай арга хэмжээнд зарцуулжээ	5
Туслах аудитор Х.Энх-Амгалан Б.Буянхишиг	Малыг бүртгэлжүүлэх ажлыг оновчтой зохион байгуулаагүй байна	6
2013 оны 11 дүгээр сар	Бүлэг 2	
	Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээнд тавих хяналт сул байна	10
Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү: www.mnao.mn	Худалдан авалтын хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна	13
	Мал эмнэлгийн эм, биобэлдмэлийн ашиглалт, зарцуулалт, хадгалалтад тавих хяналт хангалтгүй байна	14
	Дүгнэлт	17
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.	Холбогдох байгууллагын санал	18
	Зөвлөмж	19
ХАЯГ:		
Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IY байр Улаанбаатар хот 15160		

Товчилсон үгсийн жагсаалт

ЗГ	Засгийн газар
МЭҮН	Мал эмнэлэг, үржлийн нэгж
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МЭҮГ	Мал эмнэлэг, үржлийн газар
МЭҮТ	Мал эмнэлэг, үржлийн тасаг
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХТ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
НМЭГ	Нийслэлийн мал эмнэлэг, үржлийн газар
НСГ	Нийслэлийн статистикийн газар
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХААС	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд
УМЭЭААЦТЛ	Улсын мал эмнэлгийн эрүүл ахуй, ариуц цэврийн төв лаборатори
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХААЖДҮГ	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХААЖДҮГ	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд энэхүү аудитыг хийв.

Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээ, вакцинжуулалт болон Монгол мал үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгаж, дүгнэлт гаргах, үр нөлөөг дээшлүүлэх санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитаар Сангийн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, холбогдох бусад байгууллагаас хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр 2010-2012 онд гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан, баримтуудыг шалгав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн шалгалтын журам, Нийцлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг мөрдлөг болгон холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

БҮЛЭГ 1

Хөтөлбөрийн арга хэмжээнүүд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна

ТАНИЛЦУУЛГА

УИХ-ын 2010 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг баталж, эхний үе шатыг 2010-2015, дараагийн үе шатыг 2015-2021 онуудад хэрэгжүүлэхээр болсон байна.

Хөтөлбөрийн зорилго нь мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцлийг бүрдүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэгджээ.

Монгол мал үндэсний хөтөлбөрт:

1. Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбар болох мал аж ахуйг төрөөс онцгой анхаарч, эрх зүй, эдийн засаг, бүтэц, зохион байгуулалтын таатай орчин бүрдүүлж, тогтвортой хөгжлийг хангах;
2. Малын үржлийн ажил, үйлчилгээг нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн чанартай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх;
3. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, малын эрүүл мэндийг баталгаажуулах замаар нийгмийн эрүүл мэндийг хамгаалах;
4. Уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхитай мал аж ахуйг хөгжүүлэх;
5. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийг хөгжүүлж, бэлтгэл, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, урамшуулал олгох замаар эдийн засгийн эргэлтийг хурдасгах зэрэг зорилтыг тусгажээ.

Хөтөлбөрийн хууль эрх зүйн таатай орчин бүрэн бүрдээгүй байна

УИХ, Засгийн газар, ҮХААЯ-аас хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор дараах хууль, эрх зүйн актыг баталжээ. Үүнд:

- “Монгол мал” үндэсний хөтөлбөр батлах тухай УИХ-ын 2010 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоол;
- “Төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2010 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 222 дугаар тогтоол;
- “Сумдад мал эмнэлэг, үржлийн нэгж байгуулах тухай” Засгийн газрын 2010 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 223 дугаар тогтоол;
- “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль” 2011 оны 6 дугаар сарын 2-ны өдөр;
- “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2011 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 30 дугаар тогтоол;
- “Ноолууран утас, ноос боловсруулах үйлдвэрийг дэмжих, урамшуулал олгох тухай” Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 221 дүгээр тогтоол;
- “Мал хамгаалах сангийн тухай” журмыг батлах тухай Засгийн газрын 2011 оны 12 дугаар 28-ны өдрийн 374 дүгээр тогтоол;
- Отрын бүс нутгийн үйл ажиллагааны дунд хугацааны хөтөлбөр батлах тухай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2011 оны А/158 дугаар тушаал;

- Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр батлах тухай ҮХАА-н сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-166, А/24 дүгээр тушаал;
- "Малыг бүртгэх, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх тухай журам" батлах тухай ХХААХҮ-ийн сайдын 2011 оны А/74 дүгээр тушаал.

ҮХААЯ-аас мал аж ахуйн салбарын холбогдолтой зарим хуулийн төслийг боловсруулж, холбогдох газарт өргөн барьсан бөгөөд дараах байдалтай байна. Тухайлбал,

- "Мал, амьтны гүн хөлдөөсөн үр, хөврөл үрийг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай" УИХ-ын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлсэн;
- "Бэлчээрийн тухай хууль"-ийн төслийг 2011 онд боловсруулан УИХ-д өргөн барьсан;
- "Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал"-ыг "Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2010 оны 68 дугаар тогтоолтой уялдуулан боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Малын генетик нөөцийн тухай болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсэг байгуулагдсан;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлсэн;
- "Мал аж ахуйн хөгжлийн тухай хууль"-ийн төслийг боловсруулахтай холбогдсон судалгааг хийж байна.

Салбарын зүгээс хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын дунд хугацааны зорилтуудтай уялдуулан боловсруулж, шаардагдах хөрөнгийг Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх дунд хугацааны төсвийн төсөөлөл, гадаадын хөрөнгө оруулалт, зээлийн бодлоготой уялдуулан улсын болон орон нутгийн төсөв, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламж, иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр тус тус санхүүжүүлэхээр тооцжээ.

УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоолын 3-т "Монгол мал" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 3 хувиас багагүй байхаар тооцож, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгахаар заасан боловч УИХ-ын 2011 оны 64 дүгээр тогтоолоор уг заалтыг хүчингүй болгосон байна.

2010-2012 онд хөтөлбөрийн хөрөнгө оруулалт болон урсгал зардалд нийт 41.2 тэрбум төгрөг зарцуулсан байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл,

Үзүүлэлт		Мөнгөний дүн (сая төг)		
		2010 он	2011 он	2012 он
1	Хөрөнгө оруулалт		18,053.0	10,656.0
2	Урсгал төсөв	5,483.3	6,917.2	45.3
Нийт дүн		5,483.3	24,970.2	10,701.3
				41,154.8

Хөтөлбөрийн хүрээнд 2011-2012 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хуваарилсан хөрөнгө, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг шалгаж үзэхэд:

- Орхон аймгийн Мал үржлийн албанд 2012 онд олгох байсан боловч 2013 онд олгосон 5 төрлийн 26.9 сая төгрөгийн багаж хэрэгсэл, Есөнбулаг сумын МЭҮТ, "Дэвшил-Алтай" МЭҮН-д хуваарилсан модем, палкметр, жин чанарын шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй байжээ;

- Баянхонгор аймгийн Бууцагаан, Баянбулаг, Өлзийт зэрэг сумдад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөргүүр, ширээ, сандал, компьютер зэрэг 4.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 59.0 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмж, Галуут, Баянцагаан, Бууцагаан сумдад 92.2 сая төгрөгийн инженерийн хийцтэй гүн өрмийн 6 худгийг орлогод авч бүртгээгүй;
- “Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” ХХААХҮС-ын (хуучин нэрээр) 2011 оны А/202 дугаар тушаалаар хийгдсэн Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын мал эмнэлгийн барилгын 31.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засварын ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээ болон ажлын гүйцэтгэлийн акт, нотлох баримт байхгүй;
- Архангай аймгийн Цахир суманд 155.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг барих ажил гэрээнд заасан хугацаанаас хэтэрсэн зөрчил илэрч гүйцэтгэгчид 3.6 сая төгрөгийн алданги тооцож төлбөрийн акт бичигдсэн.

Энэ нь шаардлагатай хөрөнгийн тооцоо, судалгааг бодитой хийгээгүй, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр нөлөөтэй зарцуулаагүй ба “Төсвийн тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Дээрх байдал нь ХХААХҮЯ-ны (хуучин нэрээр) 2010 оны А/182 дугаар тушаалаар байгуулагдсан хөтөлбөрийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах, салбар дундын ажлын уялдаа холбоог хангаж, үр дүнд хяналт тавьж ажиллах үүрэг бүхий орон тооны бус Үндэсний Хороо зохих түвшинд үр дүнтэй ажиллаагүйг харуулж байна.

Төсвийн хөрөнгийг ач холбогдол багатай арга хэмжээнд зарцуулжээ

Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд мал аж ахуйн чиглэлийн сургалтыг мэргэжлийн байгууллага, төсөл, хөтөлбөр, орон нутгийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахад их хэмжээний хөрөнгө зарцуулжээ. Тухайлбал,

- “Монгол мал” хөтөлбөр-хөдөөгийн хөгжил” улсын зөвлөгөөнийг ХХААХҮЯ-аас (хуучин нэрээр) 2010 онд зохион байгуулж, малчдад зориулсан гарын авлага, ном, хууль эрх зүйн эмхэтгэл, *līīāīēūī āyē+ūūdēēī īāē āæ āōōē*” *ōzōōyī ōōāōāē* хэвлүүлэхэд 73.4 сая, бэлэг дурсгалд 54.0 сая, томилолтод 400.0 мянган төгрөг, нийт 127.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэж, цаашдын зорилтыг тодорхойлох “Монгол мал хөтөлбөрийн 2011 оны хэрэгжилт, 2012 оны зорилт” уулзалт, сургалт, семинар зохион байгуулж, томилолтод 662.0 сая төгрөг, *līīāīēūī āyē+ūūdēēī īāē āæ āōōē*” *ōzōōyī ōōāōāē* 20 *āīōyī*, хуулийн эмхэтгэл *ōyālүүлэхэд* 45.0 сая, “Улсын сайн малчин” шагналд (мөнгөн аяга, домбо) 80.0 сая, *līīāīēūī īāē ōīōōōō*” *āāōēīōāō ēēīī āzōūyōōd* 0,8 сая төгрөг, нийт 787.8 сая төгрөг зарцуулсан.

“Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд “Таван-Эрдэнэ” арга хэмжээг хэрэгжүүлж, малын эмч, мэргэжилтэн, малчдын төлөөлөгчдийг оролцуулсан зөвлөгөөн зохион байгуулж, гурван жил дараалан нийт мал сүрэгт угаалга, туулгалтын үнэ төлбөргүй арга хэмжээг төрөөс хариуцан хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Тухайлбал,

- Уг арга хэмжээг сурталчлахад 75.2 сая төгрөг, төлөөлөгчдөд бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 130.5 сая, өдөрлөг, сургалт зохион байгуулахад 85.5 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авах болон бусад арга хэмжээнд 66.2 сая төгрөг, нийт 357.4 сая төгрөг зарцуулсан.

Сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах хэрэгтэй боловч улсын төсвийн хөрөнгийг энэ мэтчилэн үрэлгэн, үр ашиг муутай зүйлд зарцуулсан байна.

“Монгол мал” хөтөлбөрийн 2010-2012 оны хэрэгжилт холбогдох шалгуур үзүүлэлтийг хангасан байдлыг үзэхэд 2012 оны хүрэх түвшингийн нийт 25 үзүүлэлтээс 15 нь 90-100 хувиар, 5 нь 80-90 хувиар биелэгдсэн байна. Дутуу биелэлттэй зарим үзүүлэлтийг дурдвал:

- Малын бүртгэл мэдээллийн сан, сүлжээг бий болгох ажил 68 хувь;
- Нэг малаас авах ашиг шимийн асуудал 50 хувь;
- Аймаг, сум бүрт өвс, тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн цех бий болгох ажил 70 хувь;
- Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний биржийн сүлжээ бий болгох асуудал 70 хувь.

Хөтөлбөрийн хэрэгжилт 2012 оны жилийн эцсийн байдлаар 83.4 хувьтай байна.

Малыг бүртгэлжүүлэх ажлыг оновчтой зохион байгуулаагүй байна

“Сумдад мал эмнэлэг, үржлийн нэгж байгуулах тухай” Засгийн газрын 2010 оны 223 дугаар тогтоолын дагуу сумдын Засаг даргын Тамгын газрын бүтцэд мал эмнэлэг, үржлийн үйлчилгээг зохицуулах, хянах, мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулж, тэдгээрийн үйл ажиллагаанд 2010 онд шаардагдах хөрөнгийг “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг 2010 онд хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлж, 2011 оноос эхлэн холбогдох зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлсэн байна.

ХХААХҮ-ийн сайдын (хуучин нэрээр) 2011 оны А/74 дүгээр тушаалаар Мал эмнэлэг үржлийн газрын дэргэд мал сүргийг бүртгэлжүүлэх, бүртгэл мэдээллийн ажлыг нэгдсэн зохион байгуулалттай болгох, сумдад мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий “Бүртгэл мэдээллийн алба”-ыг шинээр байгуулжээ.

ХХААХҮЯ-ны (хуучин нэрээр) ТНБД-ын 2011 оны А/281 дүгээр тушаалаар Мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжийг бэхжүүлэх ажлын хүрээнд малыг ээмэгжүүлэн бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж, малыг ялган тэмдэглэх хэрэгслийг орон нутагт хүргүүлжээ. Үүнд:

- Орон нутгийн Мал эмнэлэг үржлийн газарт компьютер, принтер, сандал, ширээ, сейф, GPS, модем, ариутгалын мотопомп хөргүүрийг 5,880.0 сая төгрөгөөр;
- Сумын мал эмнэлэг, үржлийн нэгжид олгох нэн шаардлагатай мал эмнэлгийн оношлогоо, шинжилгээний багаж, хэрэгслийг 500.0 сая төгрөгөөр, центрифуги, хөргөгч, автомат тариур, мэс заслын багажийг 1.3 тэрбум төгрөгөөр;
- Малын бүртгэл, мэдээллийн программ хангамж, компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авах, мэдээллийн нэгдсэн санг байгуулах ажлыг 425.3 сая төгрөгөөр;
- ХХААХҮЯ-наас (хуучин нэрээр) зарласан “Цөм сүргийн үржлийн малыг ялган тэмдэглэх иж бүрдэл хэрэгсэл болох 2 185 000 ширхэг бог малын ээмэг, 1426 ширхэг ээмэглэгч бахь, 380 ширхэг код уншигч төхөөрөмжийг 758.2 сая төгрөгөөр;
- “Цөм сүргийн үржлийн малыг ялган тэмдэглэх иж бүрдэл хэрэгсэл 100,000 ширхэг адууг ялган тэмдэглэх чип, 100,000 ширхэг чипний тариур, 40 ширхэг радио давтамжийг таних уншигчийг нийт 180.0 сая төгрөгөөр;
- 2012 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 100 автомашиныг худалдан авч улсын хэмжээний бүх сумын Мал эмнэлэг, үржлийн тасгууд үйлчилгээний автомашинаар бүрэн хангагдсан;
- ҮХААСайдын 2012 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/21 дүгээр тушаалын дагуу “Бод малыг ээмэгжүүлэн бүртгэлжүүлэх” ажлыг 530.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн;
- 2012 онд мал эмнэлгийн оношлогоо шинжилгээний чадавхийг сайжруулах ажлын хүрээнд мал, амьтны халдварт, гоц халдварт өвчний 907.1 сая төгрөгийн 337 нэрийн оношлуур, багаж, урвалж, туслах болон дагалдах хэрэгсэл, архаг халдварт бруцеллөз, сүрьеэ, лейкоз өвчнийг оношлох 699.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг аймаг, орон нутагт хүлээлгэн өгсөн байна.

Мал ээмэгжүүлэн бүртгэлжүүлэх, бүртгэлийн гэрчилгээ олгох, малд ялган тэмдэглэгээ хийх, багаж, техник хэрэгслийг ашиглах талаар тусгай хөтөлбөрөөр сургалт явуулж, гарын авлагаар хангахад 2011 онд 15.0 сая төгрөг, сумдын Мал эмнэлэг, үржлийн тасгийн бүртгэл мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтний сургалтыг бүх аймгуудад зохион байгуулахад 7.7 сая төгрөг, нийт 22.7 сая төгрөг зарцуулжээ.

Улсын хэмжээнд ээмэгжүүлэлтийн арга хэмжээнд нийт 7.2 сая мал хамруулах бөгөөд 4.7 сая малаас 900.0 мянган тэмээний 38 хувь, 2.3 сая үхрийн 76.0 хувь, 2,9 сая хонины 63.0 хувь, 1.9 сая ямааны 61.2 хувь, 100.0 мянган адууны 25.0 хувийг тус тус хамруулж, малын бүртгэлийн сүлжээ холбогдох 22 аймаг, нийслэл, 329 суманд малын бүртгэлийн программ хангамжийг суурилуулж 121 сум интернетэд холбогдож, малын мэдээллийн бүртгэлийн нэгдсэн санг бүрдүүлж эхэлжээ.

Малд ялган тэмдэглэгээ хийх, бүртгэлжүүлэх, мэдээллийн сан бий болгох ажлын явц зарим аймагт удаашралтай байна. Тухайлбал,

- *Завхан аймагт мэдээллийн сан бүрдүүлэн ирүүлсэн 8 сумын тайланг шалгахад зөвхөн үхрийн ээмэгжүүлэлтийн тайлан байх бөгөөд ихэнх нь дутуу хөтлөгдсөн;*
- *Орхон аймагт малыг ээмэгжүүлж мэдээллийн санд бүрэн оруулаагүй байхад уг ажлын хөлсийг хувийн МЭҮН-д бүрэн олгосноор төсвийн хөрөнгийг ашиглах боломжийг бүрдүүлжээ.*



Энэ нь мал бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах тухай гэрээний 2 дугаар зүйлийн 2.4-т “Мал бүртгэлжүүлэх үйлчилгээний хөлсийг хийсэн ажлын үр дүн, гэрээний биелэлт, акт санхүүгийн баримтын иж бүрдэл зэргийг үндэслэн олгоно”, мөн “...хийсэн ажлын үр дүн чанаргүй эсвэл ээмэгжүүлэлт, гэрчилгээжүүлэлт хийгдээгүй худлаа мэдээ гаргасан тохиолдолд үйлчилгээний хөлсийг буцаан татах арга хэмжээ авна” гэсэн гэрээний заалттай нийцэхгүй байна.

2011-2012 онд малын ээмэгжүүлэлтэд хамрагдвал зохих нийт малын 70.3%-ийг хамруулсан ба энэ нь дараах шалтгаантай байна.

- 2011 оны 10 дугаар сард малын ээмэгнүүд орон нутагт оройтож нийлүүлэгдсэнээс хүйтний улиралд малын чих хөлдөж, тасарч унадаг зэргээс малчид малаа ээмэгжүүлэх сонирхолгүй болсон;
- Ээмэгний бахьны чанар муу, хоорондоо авцалдахгүй, ээмэгний тогтоц муутай;
- Бод малыг ээмэгжүүлэхэд хүн хүч илүү шаардагддаг;
- Үйлчилгээний хөлс бага байгаагаас хувийн мал эмнэлэг уг ажилд хойрго хандаж байгаагаар холбоотой байна.

Малын бүртгэлийн ажил хоцорч байгаа зарим сумдад компьютерийн сүлжээ найдвартай ажиллахгүй байгаагаас шинэчлэгдсэн программыг сумдын МЭҮАлбад одоогоор бүрэн ашиглаж чадахгүй, программ дээр ажиллах мэргэжлийн мал зүйч байхгүй, ээмэгжүүлсэн малд олгож буй бүртгэлийн гэрчилгээний асуулга хэт нүсэр, хугацаа их шаарддаг байна.

Малыг бүртгэлжүүлэх, ээмэгжүүлэх ажил, түүний мэдээ тайлан гаргалт хангалтгүй, гүйцэтгэл гараагүй, холбогдох гэрээг дүгнээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна. Тухайлбал,

- 2011 оны эцэст Булган аймгийн Бүрэгхангай сум 748, Хангал сум 2933, Сэлэнгэ сум 1636, Баяннуур сум 3000, Дашинчилэн сум 230, нийт 8547 үхэрт ээмэгжүүлэлт хийж 169753 үхэр, 32550 хонь, 6350 ямаанд дутуу, 2012 оны жилийн эцсийн байдлаар 16 сумын 47708 үхэр, 20369 хонь, 4301 толгой ямаанд ээмэгжүүлэлтийн ажил хийгдээгүй байхад ажлыг бүрэн гүйцэтгэсэн мэтээр мэдээ тайлан гарган 39.2 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авсан;
- Ховд аймагт 375.3 мянган толгой бог, 88.3 мянган толгой бод малыг ээмэгжүүлэхэд шаардлагатай ээмэг, 10.0 мянган толгой адууны чип, 473.6 мянган ширхэг гэрчилгээ, багаж хэрэгслийг ХХААХҮЯ-аас хуваарилагджээ. Үүгээр нийт бог малын 5.5, үхрийг 100, адууны 15.9 хувийг тус тус ээмэгжүүлж бүртгэлжүүлэх боломжтой бөгөөд үйлчилгээний хөлс, тээврийн зардалд олгох 32.7 сая төгрөгийг аймгийн ХХААЖДҮГ-ын дансанд шилжүүлжээ. Уг ажлын тайлангаас үзэхэд 88.3 мянган үхэр, 67.0 мянган хонь, 43.6 мянган ямааны ээмэг гэрчилгээг авч мал эмнэлэг үржлийн нэгжүүдэд хуваарилан бүртгэлжүүлснээр 88.3 мянган бод, 110.6 мянган бог малыг хамруулсан боловч ажлын хөлсний тайланд 88.3 мянган бод, 375.3 мянган бог малыг ээмэгжүүлж, бүртгэлжүүлсэн гэж 27.6 сая төгрөгийг олгож, 10.0 мянган толгой адууны чип ирээгүйгээс 2.5 сая төгрөгийг зарцуулаагүй ба бүх малын тооноос үхэр 1387, хонь ямаа 108515 толгойгоор илүү тооцож 7.1 сая төгрөгийн хөлсийг илүү олгосон;
- Завхан аймагт 2011 онд 24 сумын 48 мал эмнэлэг үржлийн нэгж 55013 мянган үхэрт ялган тэмдэглэгээ хийж, 25187 толгой үхрийг дутуу ээмэгжүүлсэн, цөм сүргийн 216800 мянган толгой хонинд ялган тэмдэглэгээ хийж төлөвлөсөн хэмжээнээс 600 толгой хониор дутуу, цөм сүргийн 124500 мянган толгой ямаанд ялган тэмдэглэгээ хийж төлөвлөсөн хэмжээнээс 3000 толгой ямаагаар илүү ээмэгжүүлсэн тайлан гаргаж ирүүлсэн гэх боловч бодит байдал дээр уг ажил хийгдээгүй.

Дээрх байдал малыг бүртгэлжүүлэх, ээмэгжүүлэх ажил, түүний мэдээ тайлангийн гаргалт хангалтгүй, малыг ялган тэмдэглэгээ хийсний үйлчилгээний хөлсийг ажил үйлчилгээ хийгдээгүй байхад сумдын мал эмнэлгийн тасгуудад санхүүжилтийг бүрэн шилжүүлдэгтэй холбоотой байна.

Энэ нь “Мал бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах тухай” гэрээнд “мал бүртгэлжүүлэх үйлчилгээний хөлсөнд зориулан олгох санхүүжилтийн 80 хувийг урьдчилгаа болгон холбогдох дансанд нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ. Үлдэгдэл 20 хувийг хийсэн ажлын үр дүн, гэрээний биелэлт, акт, санхүүгийн баримтын иж бүрдэл зэргийг үндэслэн гүйцэтгэлээр нь олгоно” гэж заасантай нийцэхгүй байна.

УИХ-ын 2011 оны 30 дугаар тогтоолын дагуу хөтөлбөрийн хүрээнд 2011-2012 оны хугацаанд үндэсний 244 үйлдвэрт хонь, тэмээний ноос тушаасан 21 аймгийн 332 сум, 6 дүүргийн нийт 136139 малчин, мал бүхий иргэнд 29.4 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон байна. Урамшуулалд хамрагдсан малчин, мал бүхий иргэдийн болон тушаасан ноосны хэмжээ 2011 оныхоос 3 дахин өсч, бэлтгэсэн ноосны 82.5 хувийг дотоодын үйлдвэрт нийлүүлсэн байна.

Зарим аймагт ноосны урамшуулал олгосон байдлыг түүвэрлэн шалгахад сум, орон нутгийн захиалгад ороогүй, малын тооноос илүү ноосны урамшуулал олгосон зөрчил илэрлээ. Тухайлбал,

- Ховд аймгийн Дөргөн, Дуут, Эрдэнэбүрэн суманд 2011 онд ноосны урамшууллыг тоолуулсан хонины тооноос илүү болон сумын нэгдсэн захиалганд ороогүй, өөр сумын мал бүхий иргэдэд олгосноор хонь, тэмээний ноосны нийт 12.0 сая төгрөгийн урамшууллыг илүү олгосон;
- Булган аймагт малчин, мал бүхий 9689 өрхийн зөвхөн 33 хувь буюу давхардсан тоогоор 3201 өрх хамрагдсан байна.

Энэ нь Засгийн газрын тогтоол, журмыг малчдад ойлгуулах талаар холбогдох байгууллагууд тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, тэдгээр нь мэдээлэл муутайгаас бичиг баримтын бүрдэл дутуу гэсэн шалтгаанаар ноосны урамшуулалд бүрэн хамрагдаж чадаагүйг харуулж байна.

Хөтөлбөрийн уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхитай мал аж ахуйг хөгжүүлэх зорилтын хүрээнд ҮХААЯ-аас бэлчээрт хөнөөл учруулдаг үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг 13 аймгийн 90 сум, отрын 5 бэлчээрийн 500.0 мянган га талбайд энгийн механик аргаар, нэг аймгийн 6 сумын 120.0 мянган га талбайд микробиологийн аргаар зохион байгуулжээ.

Дээрх арга хэмжээний хэрэгжилтийг зарим аймагт түүвэрлэн үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал,

- *Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Галуут, Жаргалант, Заг, Гурванбулаг, Баянбулаг, Хүрээмарал, Бууцагаан, Баянхонгор сумдад оготно устгах ажлын санхүүжилтэд 2011 онд улсын төсвөөс олгосон 80.0 сая төгрөгийн 8.0 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авах, машины шатахуун, сэлбэгийн үнийг төлсөн, 2012 онд олгосон 64.0 сая төгрөгийн санхүүжилтээс шатахууны зардалд 1.9 сая, томилолтод 2.5 сая, семинарын хоол болон бичиг хэргийн зардалд 2.6 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.*

Аудитаар илрүүлсэн төлбөр зөрчлийг хавсралтаар харуулав.

БҮЛЭГ 2

Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээнд тавих хяналт сул байна

Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээний явцад үүсэх харилцаа Монгол Улсын Үндсэн хууль¹, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль болон бусад эрхийн актаар зохицуулагдаж байна.

Малын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээнд 2010 оноос өмнө жилд дунджаар улсын болон орон нутгийн төсвөөс 3.4-12.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож байсан бол 2010-2012 онд мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээнд 51.4 тэрбум төгрөг төлөвлөж, 46.6 тэрбум төгрөг зарцуулсан байна.

д/д	Зардлын ангилал	2010 он		2011 он		2012 он		Нийт дүн (2010-2012)	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Эм вакцин	3,491.5	3,485.4	10,804.2	10,803.10	8,478.2	6,984.20	22,773.9	21,272.7
2	Эрдэм шинжилгээ, судалгаа	88.3	63.1	204.0	203.9			292.3	267.0
3	Мал эмнэлгийн үйлчилгээ			5,875.3	5,875.3	7,124.1	7,121.1	12,999.4	12,996.4
4	ТӨГАУ	1,417.2	1,189.9	2,322.0	2,324.0	4,291.1	3,160.8	8,030.3	6,674.7
5	Сургалт, сурталчилгаа	7.0	6.9	84.5	79.5	230.0	220.6	321.5	307.0
6	Бичиг хэрэг, маяг			134.2	105.5	56.7	5.9	190.9	111.4
7	Багаж хэрэгсэл ЭХХАЗ			662.6	662.7	3,433.3	3,386.7	4,095.9	4,049.4
8	Хөдөлмөр хамгаалал, хувцас					272.3	45.6	272.3	45.6
9	Нөхөн олговор	294.1	69.1	1,491.9	477.3	29.1	12.3	1,815.1	558.7
10	Томилолт, тээвэр шатахуун	11.4	11.4	56.5	56.5	470.9	210.8	538.8	278.7
11	Бусад (төлбөр, хураамж)			50.0	50.6			50.0	50.6
	Дүн	5,309.5	4,825.8	21,685.2	20,638.4	24,385.7	21,148.0	51,380.4	46,612.2

Дээрх зардал нь малын халдварт болон паразиттах өвчинтэй тэмцэх, ариутгал халдваргүйжүүлэлт, лабораторийн оношлогоо, холбогдох шинжилгээ судалгаа, ажил үйлчилгээний хөлс зэрэг арга хэмжээнд зориулагддаг ба улсын төсвөөс мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ жилээс жилд нэмэгдсэн байна.

Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх арга хэмжээ, оношлогоо, шинжилгээнд шаардагдах хөрөнгийг тухайн малын өвчний эрсдэл, халдварлалт, онцлогийг харгалзан төлөвлөж, МЭҮГ-аас Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1², 15.2³-т заасны дагуу улс,

¹ 5.5-д "Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна".

² 15.1- д "Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой дараахь зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ", 15.1.2. Малын боом, галзуу, бруцеллэз, цусан халдвар, сүрхсвээ, лейкоз, томуу, цусан суулга, листериоз, үхрийн дуут хавдар, хорт салст халуурал, эфемер чичрэг, адууны ям, халдварт цус багадалт, сахуу, уушиг гялтангийн халдварт үрэвсэл, бог малын дотрын халдварт хордлого, брадзот, энтеробактериоз... өвчнүүдээс урьдчилан сэргийлэх, оношлоход шаардагдах эм, биобэлдмэлийн үнэ; 15.1.3.Малын цусны шимэгчээр үүсдэг өвчин, хамуу, шимэгч хорхойтох өвчнөөс сэргийлэхэд хэрэглэх эмийн үнэ

³ 15.2-т "Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон дараахь зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ". Энэ хуулийн 15.1.2-т заасан өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлоход шаардагдах үйлчилгээний хөлс,

орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг байна. Одоогийн байдлаар улсын хэмжээнд 329 суманд мал эмнэлэг, үржлийн тасаг, хувийн 862 мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгж ажиллаж байна.

Хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн тоо 2010 онд 9 байсан бөгөөд 2011 онд 17, 2012 онд 57 нэгж шинээр байгуулагдаж, нэг МЭҮН-д ногдох малын тоо 2010 онд 2941 толгой, 2011 онд 6190 толгой, 2012 онд 1423 толгой, нэг малын эмчид ногдох малын тоо 2010 онд 1661 толгой, 2011 онд 2850 толгой, 2012 онд 1211 толгойгоор тус тус багассан нь малын эмчийн ажлын ачаалал буурсныг харуулж байна.

Малын гоц халдварт шүлхий, хонь, ямааны цэцэг, гахай, шувууны гоц халдварт өвчний эрсдэл, тархалтыг харгалзаж вакцинжуулалтад хамрагдах аймаг, сумыг тодорхойлж, шаардлагатай тун вакциныг орон нутагт хүргүүлдэг байна.

Манай орны хувьд малчин, мал бүхий иргэд нүүдэллэн амьдардаг, зарим өрх гэрийн засаг захиргааны бүртгэл будлиантай, малын тооллого асуумж хэлбэрээр хийгддэгээс шалтгаалж малын тоо статистикийн газрын тооноос зөрүүтэй гардаг байна.

Үүнээс шалтгаалан гоц халдварт, халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад малчин, мал бүхий иргэд малаа бүрэн хамруулахгүй байх, өвчин гарах зэрэг эрсдэл тохиолддог байна. Тухайлбал,

-Нийслэлийн статистикийн газраас ирүүлсэн малын тоонд үндэслэж вакцин болон үйлчилгээний хөлс олголтыг тооцож үзвэл 2011 онд хонины тоог 114.5 мянгаар нэмэгдүүлж 114.5 мянган тун буюу 3.5 сая төгрөгийн вакцин, 9.7 сая төгрөгийн үйлчилгээний хөлсийг илүү олгосон байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл,

Он	Малын нэр	Вакцины нэр	НСГ-аас ирүүлсэн хонины тоо	Хувийн МЭҮН-ээс ирүүлсэн хонины тоо	2011 онд вакцинд хамрагдахаар төлөвлөсөн хонины тоо	Вакцин олгосон хонины тоо	Вакцин тарьсан үйлчилгээний хөлс олгосон хонины тоо
2011	Хонь	Хонины цэцэг	105 745	108 024	220 200	220 200	202 814

Цаашид засаг захиргааны бүртгэлийг үл харгалзан тухайн нутаг дэвсгэрийн голомтын бүсэд байгаа малыг вакцинжуулалтад бүрэн хамруулах шаардлагатай байна.

Вакцинжуулалтын үйлчилгээний хөлсийг 21 аймаг, нийслэлд олгохдоо тухайн аймаг, сумын засаг даргын захирамж, аймгийн МХГ, сумын мал эмнэлгийн улсын байцаагчийн дүгнэлт, орон нутгийн Мал эмнэлгийн албанаас гаргасан тооцоо, тарилга хийсэн актыг үндэслэдэг ба 2010 онд бог 100, бод 150 төгрөг, 2011-2012 онд бог 150, бод 200 төгрөгөөр тус тус тооцжээ.

Нийслэлийн төсөв болон дүүргийн Засаг Даргын нөөц сангаас 2011, 2012 онд НМЭГ-т мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, вакцинжуулалтад зориулж олгосон санхүүжилтийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад ҮХААЯ-ны МЭҮГ-аас 2012 онд НМЭГ-т шүлхий өвчний эсрэг вакцин тарьсны үйлчилгээний хөлсийг зориулалт бусаар зарцуулах зөрчил гаргасан. Тухайлбал,

- *Нийслэлийн мал эмнэлгийн газар 2012 онд шүлхий өвчний эсрэг вакцин тарьсны үйлчилгээний хөлс болох 1.8 сая төгрөгийг зориулалт бусаар /суудлын бүрээс, автомашины дугуй, олгой хаймар/ зарцуулсан;*

- 2012 онд интернетийн төлбөр 1.2 сая, лабораторийн шинжилгээний хөлс 3.7 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр улсын төсөвт шилжүүлсэн байна.

Дээрх зөрчлийг арилгуулахаар 6.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Зарим аймагт вакцинжуулалтын үйлчилгээ үзүүлэх туслах ажилтан дутмаг байдгаас малчид тарилга тарихаас бусад бүх ажлыг өөрсдөө хийдэг, хүн хүч багатай айл өрх малаа барьж өгч чадахгүйгээс үйлчилгээнд хамрагдахгүй орхигддог ба дараа нөхүүлэн хийлгэх боломжгүй болох явдал гарч байна. Мөн халдварт өвчнөөс сэргийлэх тарилгын санхүүгийн анхан шатны баримт засвартай, дутуу бүрдэлтэй зэрэг зөрчил гарч байна. Тухайлбал,

- Өрхөд тоологдсон малын тооноос нэмж бичин вакцины хэвийн хорогдлыг тарьснаар бичин үйлчилгээний хөлс илүү олгосон 228.5 мянган төгрөгийг шалгалтын хугацаанд төлүүлж, малчны малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийгдээгүй, мал тооллогын данснаас илүү бичиж байгаа зөрчилд 49.2 сая төгрөгийн албан шаардлага бичлээ.
- Төв аймагт 2011-2012 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар олгосон 215.1 сая төгрөгийн ивомекийг малд тарилга боловсруулалт хийсэн үйлчилгээний хөлс авах болзолтойгоор олгосон байдлыг шалгахад сум бүрт бүрэн очиж, хувийн зарим мал эмнэлэг малчдыг өөрсдөө тарь гэж үнэгүй малчдад олгох, зарим нь малд хийх үйлчилгээний хөлсний жишгээр үнэлэн худалдах, зарим нь малчдад тарилга хийсэн бүртгэлийн жагсаалт бичиж тайлан гаргасан.
- Ховд аймгийн МЭГ-т 2011 онд хуваарилсан вакцин малын тооноос зөрүүтэй байснаас 7.0-14.6 сая төгрөгийн вакцин тарьсны хөлсийг мал эмнэлгүүдэд илүү олгосон.

Үүний зэрэгцээ мал эмнэлгийн эмчлэн сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлж буй сум, дүүрэг, багийн малын эмч нарт төсвөөс олгодог үйлчилгээний зардал зах зээлийн бодит үнэлгээнээс харьцангуй бага байгаа нь ажил үйлчилгээний чанар, аж ахуйн үйл ажиллагааны хэвийн байдалд сөргөөр нөлөөлж байна.

ҮХААЯ-ны МЭҮГ аймаг, орон нутагт шилжүүлсэн санхүүжилтэд хяналт шалгалт хийх эрхгүй тул зөвхөн санхүүгийн материалыг хянан санхүүжилт олгодог байна. Гэтэл санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулах, мал эмнэлгүүд вакциныг норм хэмжээнээс дутуу тарих, хүлээн авсан болон зарцуулсан вакцины хэмжээ зөрүүтэй байх зөрчлүүд гарсан байна. Тухайлбал,

- Завхан аймагт вакцинжуулалтын санхүүжилтээс үлдсэн 10.7 сая төгрөгөөс 6.3 сая төгрөгийг аймгийн мал эмнэлгийн лабораторид хяналтын шинжилгээнд, 4.4 сая төгрөгийг ажлын хөлсөнд олгосон;
- Мөн аймгийн ХХААЖДҮГ Засаг даргын 2011 оны 197 дүгээр захирамжийн дагуу бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын 63.6 сая төгрөгийн 1.0 сая төгрөгийг халдварт өвчний тандах шинжилгээ болон вакцинжуулалтын ажлын тайланг хүргэх зардалд зарцуулсан;
- Баянхонгор аймагт малын вакцинжуулалтын ажлын хөлснөөс “Дөвөнтийн нөмөр” мал эмнэлэгт малын цус авсан гэж 3.0 сая, “Буянт хөөвөр” мал эмнэлэгт урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 8.2 сая, “Говийн хишиг” мал эмнэлэгт 1.2 сая, нийт 12.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан тул дээрх аж ахуйн нэгжүүдээр нөхөн төлүүлэхээр акт тогтоосон;
- 2012 онд ХХААХҮЯ-наас (хуучин нэрээр) 16303 толгой малд хээл хаялтын шинжилгээ хийх 20.8 сая төгрөгийг Архангай аймгийн ХХААЖДҮГ Газарт хуваарилсан ба 15538 толгой малд 18.2 сая төгрөг зарцуулж, 765 толгой мал шинжилгээнд хамрагдаагүйгээс үлдсэн 2.6 сая төгрөгийг Мал эмнэлгийн албаны шатахуун, томилолт, хөрөнгө худалдан авахад зарцуулсан байна;
- Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын ХХААЖДҮГ Газарт 2011 онд хуваарилсан мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн хэмнэлт 7.2 сая төгрөгийг сум хөгжүүлэх санд шилжүүлсэн;

- Мөн аймагт 2011-2012 онд хуваарилсан малын биобэлдмэлүүдийг зохих зааврын дагуу зарцуулсан эсэхийг шалгаж үзэхэд 2011 онд Суугт, Гурвалжин тан, Сөнхөл, Ариун нуур, 2012 онд Царцаа хоршоо, Шандны тохой, Занданбайгаль, Ачит халиун зэрэг мал эмнэлгүүд вакциныг норм хэмжээнээс дутуу тарьсан, хүлээн авсан болон зарцуулсан вакцины тоо хэмжээ зөрүүтэй байна.

Ийнхүү орон нутагт “Малын удмын сан, эрүүл мэндийн тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.5.1-д “мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээнд тухайн нутаг дэвсгэр дэх малыг бүрэн хамруулах, ажил, үйлчилгээг гэрээ, захиалгаар гүйцэтгүүлэх” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, хувийн мал эмнэлгийн газрууд гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлээгүй, тэдгээрийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт сул байна.

Худалдан авалтын хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, вакцинжуулалтад шаардагдах эм, био бэлдмэлийг худалдан авахдаа “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг төлөвлөх, санхүүжүүлэх журам”-ын 1.2⁴-т заасны дагуу орон нутагт шаардагдах мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбогдох малын эм, биобэлдмэлийн захиалгыг аймаг, нийслэлийн Хөдөө аж ахуйн газрын Мал эмнэлгийн албаар дамжуулан ҮХААЯ-ны МЭҮГ нэгтгэдэг байна.

Биокомбинат ТӨААТҮГ-тай “Мал эмнэлгийн зориулалттай биобэлдмэл” нийлүүлэх гэрээгээр 2010 онд мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх зориулалт бүхий 25 нэрийн 3.5 тэрбум, 2011 онд 4.0 тэрбум төгрөгийн, 2012 онд 5.3 тэрбум төгрөгийн оношлуур, биобэлдмэлийг 21 аймаг, нийслэлийн ХХААЖДҮГ, Мал эмнэлгийн албанд нийлүүлсэн байна.

ҮХААЯ-ны МЭҮГ-аас 2012 онд зохион байгуулсан зарим төсөл, арга хэмжээ, тоног төхөөрөмж худалдан авах тендерийн бичиг баримтыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу баталгаажуулаагүй, түүнд агуулагдах ёстой баримт бичгийг бүрдүүлээгүй, архивын нэгж болгон хадгалаагүй зөрчил гарч байна.

Орон нутагт нийлүүлэгдсэн зарим багаж, тоног төхөөрөмжийн ашиглалт, малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг хүлээлгэн өгсөн байдлыг зарим аймагт шалгаж үзэхэд мал эмнэлгийн албанд нийлүүлэгдсэн багаж, тоног төхөөрөмж ажиллахгүй, шаардлага хангахгүй, техникийн тодорхойлолт, ашиглах дэлгэрэнгүй зааврыг албан ёсоор хүлээлгэн өгөөгүй, зохих сургалтыг явуулаагүй зэрэг зөрчил илэрсэн байна. Тухайлбал,



- “Төгс үчинбэр” ХХК вакцин хадгалах хөргүүрийг Говьсүмбэр аймгийн ХХААЖДҮГ-т хүлээлгэн өгөхдөө зориулалтын бус байранд суурилуулж, хөргөлтийн камерийг ашиглах заавар, техникийн тодорхойлолт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг ашиглагч байгууллагад албан ёсоор хүлээлгэн өгөөгүй зэргээс үүдэн тухайн хөргүүрт хадгалагдаж байсан вакцины хүйтэн хэлхээний хадгалалтын горим зөрчигдөж, хөргүүрт хадгалж байсан 55, 66, 67, 35, 37, 38, 39, 48 цувралын дугаартай 3850 л малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинаас 1451.2 л буюу 7256 ширхэг шил буюу 317.2 сая төгрөгийн үнэ бүхий шүлхий өвчнөөс сэргийлэх вакциныг хөлдөөснөөс стандартын шаардлага хангахгүй болж, МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлтээр мал эмнэлгийн албаны хөргүүрийн ашиглалтыг зогсоож, чанарын шаардлага хангахгүй болсон вакциныг актаар устгасан байна.

⁴ “Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрууд сум, дүүргийн мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг хянаж, нэгтгэн Улсын мал эмнэлгийн албаны ерөнхий газарт 7 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ”

Зарим аймагт ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлтэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, мөн “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой дараах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ”, мөн 15.2-т “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон дараах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчиж байна. Тухайлбал,

- *Булган аймгийн Засаг даргын 2012 оны 495 дугаар захирамжаар малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлоход шаардагдах үйлчилгээний хөрөнгөөр “Малчин монгол” ХХК-иас циперметрин 500 кг-ийг 7.0 сая төгрөгөөр худалдан авсан;*
- *Бруцеллёз өвчтэй малыг устгах нөхөн олговорт ХХААХҮЯ-ны Мал эмнэлэг үржлийн газраас Архангай аймагт 2011 онд 236.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноос 1551 үхрийн нөхөн олговрын хөрөнгөөр Цахир сумын Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын бүсийн оффисын тавилга, компьютер, техник хэрэгсэл авах, ажилтнуудын цалин, үйл ажиллагааны зардалд 32.6 сая, мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын бүсэд ачааны фургон машин худалдан авахад 23.0 сая төгрөг, аймгийн ХХААЖДҮГ-ын Мал эмнэлгийн албанд УАЗ-469 автомашиныг 22.0 сая төгрөг, мал эмнэлгийн явуулын лабораторийн автомашины гараж барихад 40.0 сая төгрөг, Архангай аймгийн адуун сүргийн удмын санг сайжруулах төсөл хэрэгжүүлэх нэрээр хувь хүнд (Хасу мандал ХХК) 55 тооны адууг худалдан авахад 100.0 сая төгрөг, нийт 217.6 сая төгрөгийн худалдан авалтыг ХХААХҮСайдын 2012 оны 1/2359 дүгээр албан бичгийн дагуу хийсэн;*
- *Бруцеллёзын шинжилгээгээр өвчтэй болох нь тогтоогдоогүй 12 үнээнд Дархан-Уул аймгийн Дархан сумын Мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга О.Цэцгээ, малын эмч Н.Гэрэлцолмон, Ц.Нарантуяа нар малын нядалгаа хийсэн тухай актыг хуурамчаар бүрдүүлж, аймгийн ХХААЖДҮГ-ын Мал эмнэлгийн албаны дарга Х.Хавсаметын шийдвэрийг үндэслэн 2.2 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна.*

Дээрх байдал нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 17-ийн 1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ”, мөн “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль”-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Мал эмнэлгийн эм, биобэлдмэлийн ашиглалт, зарцуулалт, хадгалалтад тавих хяналт хангалтгүй байна

Биокомбинат ТӨААТҮГ мал амьтдыг гоц халдварт, халдварт өвчнүүдээс сэргийлэх зориулалт бүхий 30-аад нэрийн оношлуур, 8 нэрийн эсрэг-ийлдэс буюу иммуноглобулин үйлдвэрлэж байна. Тус үйлдвэрийн зарим тоноглол нь олон улсын стандартын шаардлагаас хоцрогдсон, сэлбэг хэрэгсэл нь гадаад орнуудад үйлдвэрлэгдэхээ больсон тул засаж сэлбэх боломжгүй болсон байна.

Зарим дүүргийн хувийн мал эмнэлгийн газруудад хуваарилагдсан эм, тарилга вакцин, био бэлдмэл, угаалга ариутгал, туулгалтын бодис малчин өрх, мал бүрт хүрч байгаа эсэхийг вакцин, угаалга туулгалт хийсэн акт, жагсаалт, бусад холбогдох баримт материалтай тулгаж үзэхэд Багануур, Багахангай дүүргүүдийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн байцаагч нар хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, зарим хувийн мал эмнэлгийн газрын малын эмч нар нийлүүлэгдсэн вакциныг зохих хугацаанд хийгээгүй байна.

- *Дээрх дүүргийн 20 малчин айлаар ороход 1 өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт байцаагчийн хяналт хийсэн тухай тэмдэглэл бичигдсэн ба Багахангай дүүргийн байцаагч 2012 оны 5 дугаар сараас 2013 оны 6 дугаар сарын 5-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаанд малчин өрхөөр явж хяналт хийгээгүй;*

- *Налайх дүүргийн хувийн мал эмнэлгийн газарт 2012 оны 4 дүгээр сард нийлүүлэгдэх ёстой боомын вакцин 6 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар ирээгүй;*
- *Хан-Уул дүүргийн хувийн мал эмнэлгийн газарт боомын вакцин 4 дүгээр сард буюу хугацаандаа нийлүүлэгдсэн боловч хариуцсан малын эмч нь вакцинаа хийгээгүй;*
- *Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх, вакцинжуулалтын арга хэмжээнд төсвөөс олгодог үйлчилгээний хөлсийг олгохдоо бог мал 300, бод мал 400, амьтан 600, шувуу 100 төгрөгийн нормативт үнэлгээтэй боловч дунджаар бог малд 150-200, бод малд 250-300, амьтанд 400-500 төгрөгөөр тооцож, мөнгөн хэлбэрээр олгож, зөрүүг бараагаар буюу дутуу олгох байдал гаргасан байна.*

Мал эмнэлгийн байгууллагаас малын халдварт өвчний эрсдэл бүхий хэсэгт бүрэн хяналт тавиагүй, зөвхөн аймгийн Засаг даргын үзлэг зэрэг бусад ажлаар хөдөө явах үед сумдын Мал эмнэлэг үржлийн тасгийн ажил болон мал эмнэлгийн нэгжүүдийн тарилгын ажлын явц байдлыг шалгадаг бөгөөд зарим сумдын мал эмнэлгийн хяналтын байцаагч сумдын Мал эмнэлэг, үржлийн тасаг, нэгжүүдийн зүгээс тавих хяналт хангалтгүй байна. Тухайлбал:

- *Булган аймагт 42 мал эмнэлэг үржлийн нэгжид үйлчилгээний хөлсөнд 344.6 сая төгрөг олгосон гэж тайлагнасан боловч нийт 670.0 мянган төгрөгийг Дашинчилэн, Сэлэнгэ, Бүрэгхангай сумын Мал эмнэлэг үржлийн нэгжүүдэд илүү олгосон, үлдэгдэл 1.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;*
- *Завхан аймагт вакцинжуулалтын үйлчилгээний хөлснөөс 4.4 сая төгрөгийг гэрээт ажилтнуудад ажлын хөлс төлж төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, мөн 2010 онд сумдын мал эмнэлгийн хоршоодын вакцинжуулалтын тайлангийн баримтын бүрдүүлэлт хангалтгүй, аймгийн ХХААЖДҮГ-аас үйлчилгээний хөлсийг вакцинжуулсан малын тооноос 35.5 мянган малаар бууруулан олгосон;*
- *2012 онд Архангай аймгийн мал сүргийг ивомекийн боловсруулалтанд бүрэн хамруулахаар 261.0 сая төгрөгийн 4444.3 литр ивомек тариа нийлүүлэгдснийг хувийн хэвшлийн 36 аж ахуйн нэгжид хуваарилан олгосон бөгөөд аймгийн төв, Эрдэнэбулган сумын багууд болон Цэнхэр, Батцэнгэл, Ихтамир, Булган, Хашаат, Хотонт сумдын мал эмнэлгээс ивомек тараасан хуваарийг сумдын хувийн эмнэлгүүдээс ирүүлсэн мэдээтэй тулгахад тарилгыг хийсэн эсэх нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байсан зэрэг зөрчилд 13.9 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдсэн.*

Энэ нь “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.6-д “...мал эмнэлэг, үржлийн холбогдолтой тайлан мэдээ гаргуулж, хяналт тавих” гэсэн заалтыг зөрчсөн, улсын төсвөөс санхүүжүүлсэн ивомек тарианы тарилгыг хувийн мал эмнэлгүүд хэрхэн хийж байгаад аймаг, сумдын Мал эмнэлгийн үржлийн тасгаас тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Салбарын хувьд зарим хүндрэлтэй асуудал гардаг байна. Тухайлбал,

- *1999 онд өмч хувьчлалаар байгуулагдсан мал эмнэлгийн нэгжүүдийн ихэнх нь материаллаг баазын хувьд хангалттай бэхжиж чадаагүй, мэргэжлийн боловсон хүчин дутмаг байдгаас ажил, үйлчилгээндээ мэргэжлийн бус хүнээр туслуулдаг, мөн малчдыг оролцуулдаг учир зарим ажил үйлчилгээний чанар хангалтгүй байдаг;*
- *Ихэнх вакцины захиалга тухайн орон нутгийн өмнөх оны малын тооллогын дүнд тулгуурласан байдаг, зарим дүүрэг болон аймагт малын шилжилт хөдөлгөөн их, түүнд тавих хяналт сул байгаагаас захиалга хийгдсэнээс хойш малын тоонд өөрчлөлт гарч тэр хэмжээгээр орон нутгийн хувийн мал эмнэлгийн захиалгын тоо хэмжээ бодитой бус болдог байна.*

Жилийн эцсийн мал тооллогоор өрхөд тоологдсон малын тоог нэмж бичиж, вакцины хэвийн хорогдлыг тарьсан болгон үйлчилгээний хөлс илүү авдаг зөрчил түгээмэл байна. Тухайлбал,

- *Булган аймагт 2011 онд бод 182400, бог 480000, нийт 662400 толгой малд өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний захиалга өгсөн боловч бод 57200, бог 138400 нийт 195600 толгой малд урьдчилан сэргийлэх тарилга хийсэн бөгөөд захиалгаас бод 122000, бог 338400 толгой буюу бод 66.9, бог 70.5 хувиар тус тус хасч баталсан;*
- *Вакцинжуулалтын арга хэмжээний гүйцэтгэлийг жилийн эцсийн малын А данстай түүвэрлэн тулгахад ихэнх сумд өрхөд тоологдсон малын тооноос нэмж бичин вакцины хэвийн хорогдлыг тарьсан болгон үйлчилгээний хөлс илүү авсан;*
- *Малчны малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийгдээгүй, мал тооллогын данснаас илүү бичиж байгаа зөрчилд 35,6 сая төгрөгийн албан шаардлага бичсэн.*

Вакцинжуулалтад малыг хамруулж байгаа боловч малын эрүүл мэндийн дэвтэрт малчин болон мал эмнэлэг, үржлийн аж ахуйн нэгжийн эмч нар бичилт хийн ашиглаж хэвшээгүй, сумын мал эмнэлэг, үржлийн тасгийн улсын байцаагч хангалттай хяналт тавьдаггүйгээс уг дэвтрийн ач холбогдол алдагдсан, үр дүн хангалтгүй байна.

Дүгнэлт

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн тоо нэмэгдэж, Мал эмнэлэг, үржлийн нэгж болон нэг малын эмчид ногдох малын тоо жил дараалан буурч байгаа нь тэдний ажлын ачааллыг бууруулах, мал эмнэлгийн үйлчилгээний чанарт ахиц гаргах боломж олгож байна.
2. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх малын эзмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийн ажил удаашралтай, малын бүртгэл мэдээллийн сан хангалтгүй ажиллаж байна.
3. Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээ, вакцинжуулалтын ажлын гүйцэтгэлд холбогдох газруудаас тавих хяналт хангалтгүй байна.
4. Вакцин хадгалах хөргүүрийг зориулалтын бус байранд суурилуулж, хөргөлтийн камерийг ашиглах заавар, техникийн тодорхойлолт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг ашиглагч байгууллагад албан ёсоор хүлээлгэн өгөөгүйгээс хадгалалтын горим зөрчигдөж, вакцины чанар алдагдахад хүргэсэн байна.

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26-22-71, Факс: (976-11) 45-31-21,
E-mail: mofa@mofa.gov.mn; <http://www.mofa.gov.mn>

2013.11.28 № 01/1031
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТЫН ОРЛОГЧ Б.БАТБАЯР ТАНАА

Үндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээ, вакцинжуулалт болон Монгол мал үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт”-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын тайланд тусгагдсан зөрчилтэй асуудлуудын дийлэнх хувь нь орон нутагт зохион байгуулагдсан байгааг анхаарах нь зүйтэй байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Х.ЗОЛЖАРГАЛ



0000005188

Жижиг албан бичиг 2013

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад:

1. “Монгол мал” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийн төслийг боловсруулж, зохих журмын дагуу батлуулах арга хэмжээ авах.
2. Хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэх, гүйцэтгэгчийн хариуцлага, захиалагчийн хяналтыг чангатгах арга хэмжээ авах.

ҮХААЯ-ны Мал, эмнэлэг үржлийн газрын даргад:

1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, вакцинжуулалтын үйлчилгээний хөлсийг төлөвлөх, захиалах, хуваарилах, хянан баталгаажуулах ажлыг сайжруулах арга замыг холбогдох байгууллагатай хамтран судалж, санал боловсруулан шийдвэрлүүлэх.
2. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй малын ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийн ажлыг эрчимжүүлж, үйлчилгээний хөлсний үнэ тарифыг оновчтой болгох асуудлыг судлан холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх.
3. Малын эм, биобэлдмэл, тарилга, туулгалт, угаалга, халдваргүйжүүлэлтийн бодисыг зориулалтын байранд хадгалж байх журам гаргаж мөрдүүлэх.
4. Малын халдварт, гоц халдварт болон паразиттах өвчний тандалт, судалгааг нарийвчлан гаргаж, түүнд тавих хяналтыг сайжруулах.
5. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний санхүүжилт, нийлүүлэгдсэн үндсэн хөрөнгө, тоног, төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 196

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, 15.3, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээ, вакцинжуулалт болон Монгол мал үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт"-д хийсэн аудитын тайлан, аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн Байнгын хороо болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2014 оны 3 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад зөвлөсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Нийцлийн аудитын газар (аудитын менежер Б.Алтанзул)-т үүрэг болгосугай.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД

070543
tushaal-2013

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2013 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн 196 дугаар тушаалын хавсралт

Аудитаар илрүүлсэн төлбөр, зөрчлийн жагсаалт

№	Хариуцах албан тушаалтан, байгууллагын нэр	Төлбөр, зөрчлийн товч утга	Төлбөр, зөрчлийн нийт дүн	Акт	Албан шаардлага	Үүнээс		Төгрөгөөр
						Аудитын явцад барагдуулсан Төлбөр	Зөрчил	
Булган аймгийн аудитын газар								
1	ХХААХДҮГ-ын дарга О.Гантулга Нягтлан бодогч Ц.Хажидмаа	Адууны халдварт цус багадах өвчний шинжилгээг хийхдээ Хутаг-өндөр сумын Уныт багийн 2096 адууны шинжилгээг Бүрэгхангай сумын "Бүрэг морьт" мал эмнэлэг үржлийн нэгж хийсэн гэж хуурамч гэрээ хийж бэлнээр авсан. /2010 он/	524,000.0	524,000.0			524,000.0	
2	ХХААХДҮГ-ын дарга О.Гантулга Нягтлан бодогч Ц.Хажидмаа	Адууны халдварт цус багадах, ям, шүлхий өвчний шинжилгээний зардлыг албан хаагчдын хувийн харилцах дансанд шилжүүлж эргэж тооцоо хийгээгүй дутагдуулсан /2010 он/	3,046,650.0	2,522,650.0	524,000.0		524,000.0	
3	ХХААХДҮГ-ын дарга О.Гантулга Нягтлан бодогч Ц.Хажидмаа	Үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй /2010 он/	375,000.0		375,000.0			375,000.0
4	ХХААХДҮГ-ын дарга О.Гантулга Нягтлан бодогч Ц.Хажидмаа	Булган сумын "Хайлантайн гол", Бүрэгхангай сумын "Их гозгор", Хангал сумын "Тавхайн залаа", Сайхан сумын "Угалз сайхан" мал эмнэлэг үржлийн нэгжүүдэд үйлчилгээний хөлс нийт 4900.0 мянган төгрөг илүү олгосон /2010 он/	4,900,000.0	4,900,000.0			4,900,000.0	
5	ХХААХДҮГ-ын дарга О.Гантулга Нягтлан бодогч Ц.Хажидмаа	Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хуулийн 15.2, ТБОНӨХБАХАТухай хуулийн 8.2 дахь заалтуудыг зөрчиж худалдан авалт хийсэн /2011 он/	11,865,406.0	7,000,000.0	4,865,406.0			4,865,406.0
6	ХХААХДҮГ-ын дарга О.Гантулга Нягтлан бодогч Ц.Хажидмаа	Урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсийг илүү олгосон /2011 он/	100,170.0		100,170.0			100,170.0
7	ХХААХДҮГ-ын дарга О.Гантулга Нягтлан бодогч Ц.Хажидмаа	Хөрөнгийг бүртгэлд дутуу тусгасан /2011 он/	4,917,560.0		4,917,560.0			4,917,560.0
8	Сумын засаг дарга Р.Батшиг	Ноосны урамшууллаас ХХОАТ дутуу тооцсон	11,395,700.0	11,395,700.0			11,395,700.0	
9	Төрийн сангийн төлөөлөгч Г.Оюун-Эрдэнэ		2,307,000.0	2,307,000.0			2,307,000.0	
10	Сумын засаг дарга М.Зоригт	Ноосны урамшууллаас ХХОАТ дутуу тооцсон	8,074,600.0	8,074,600.0			8,074,600.0	
11	Төрийн сангийн төлөөлөгч М.Энхчимэг		2,539,100.0	2,539,100.0			2,539,100.0	
12	Сумын засаг дарга П.Цэнд-Аюуш	Ноосны урамшууллаас ХХОАТ дутуу тооцсон	1,200,000.0	1,200,000.0				
13	Төрийн сангийн төлөөлөгч Д.Бямбаа		450,000.0	450,000.0			450,000.0	
14	Сумын засаг дарга О.Оюун	Ноосны урамшууллаас ХХОАТ дутуу тооцсон	528,000.0	528,000.0			528,000.0	
15	Төрийн сангийн төлөөлөгч Г.Бурмаа		220,000.0		220,000.0			220,000.0
16	ХХААХДҮГ-ын дарга О.Гантулга Нягтлан бодогч Л.Отгон	Үйлчилгээний хөлсийг зориулалт бусаар зарцуулсан 2012 он/	607,000.0	607,000.0				
17	ХХААХДҮГ-ын дарга О.Гантулга Нягтлан бодогч Л.Отгон	Үйлчилгээний хөлсийг илүү олгосон /2012 он/	629,500.0	629,500.0				
18	ХХААХДҮГ-ын дарга О.Гантулга Нягтлан бодогч Л.Отгон	Адууны халдварт цус багадах, ям, шүлхий өвчний шинжилгээний зардлыг албан хаагчдын хувийн харилцах дансанд шилжүүлээд эргэж тооцоо хийгээгүй /2012 он/	84,550.0		84,550.0			

19	Халдварын эмч Р.Түвшин-Эрдэнэ	Үйлчилгээний хөлс илүү олгосон /2012 он/	308,476.0	308,476.0		
20	ХХААХДҮГ-ын дарга О.Гантулга Л.Отгон	Томилогт, шатахууны зардлыг давхардуулан олгосон /2012 он/	12,082,700.0		12,082,700.0	
21	ХХААХДҮГ-ын дарга О.Гантулга Л.Отгон	Томилогтын зардлыг илүү олгосон /2012 он/	218,500.0		218,500.0	
22	ХХААХДҮГ-ын дарга О.Гантулга Л.Отгон	Үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгааргүй /2012 он/	150,000.0	150,000.0		150,000.0
23	Баян-Агт Цэгээн булаг	Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	10,946,100.0		10,946,100.0	
24	Сумын Засаг дарга	Вакцинжуулалтын үйлчилгээний хөлсийг илүү олгосон	78,400.0		78,400.0	
25	Сумын Засаг дарга	Вакцинжуулалтын үйлчилгээний хөлсийг илүү олгосон	21,840,100.0		21,840,100.0	
26	Булгат Гал бүрэн	Бруцеллезын малын тарилга хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	71,550.0	71,550.0		71,550.0
27	Номгон хан	Бруцеллезын малын тарилга хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	52,000.0	52,000.0		52,000.0
28	Сумын Засаг дарга	Вакцинжуулалтын үйлчилгээний хөлсийг илүү олгосон	279,900.0		279,900.0	
29	МЭУТасаг	Эмэгжүүлэлтийн ажлын гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгосон	100,000.0	100,000.0		100,000.0
30	Булган Хайлантайн гол	Бруцеллезын тарилга хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	100,000.0	100,000.0		100,000.0
31	Наран халтар	Бруцеллезын тарилга хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	100,000.0	100,000.0		100,000.0
32	МЭУТасаг	Эмэгжүүлэлтийн ажлын гүйцэтгэл дутуу байхад санхүүжилт бүрэн авсан	22,703,400.0		22,703,400.0	
33	Бүрээхантай, Бүрээг морьт	Бруцеллезын тарилга хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	617,200.0		617,200.0	
34	Их гозгор	Бруцеллезын тарилга хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	50,000.0	50,000.0		50,000.0
35	Алтагбичигт	Бруцеллезын тарилга хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	20,000.0	20,000.0		20,000.0
36	Сумын Засаг дарга	Бруцеллезын тарилга хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	100,000.0	100,000.0		100,000.0
37	МЭУТасаг	Эмэгжүүлэлтийн ажлын гүйцэтгэл дутуу, санхүүжилт бүрэн авсан	20,000.0	20,000.0		20,000.0
38	Гураванбулаг ГМЭ	Бруцеллезын тарилга хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	80,000.0	80,000.0		80,000.0
39		Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	12,000.0	12,000.0		12,000.0
40	Гандайт	Бруцеллез хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	116,000.0	116,000.0		116,000.0
41		Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	30,000.0	30,000.0		30,000.0
42		Бруцеллез хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	288,000.0	288,000.0		288,000.0
43	Дарий улаан	Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	178,026.0	178,026.0		
44	Шүүлт	Бруцеллез хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	150,000.0	150,000.0		150,000.0
45		Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	150,000.0	150,000.0		
46	МЭУТасаг	Эмэгжүүлэлтийн ажлын гүйцэтгэл дутуу, санхүүжилт бүрэн авсан	15,528,500.0	15,528,500.0		15,528,500.0
47	Засаг дарга Ц.Бат-Өлзий		269,700.0	269,700.0		269,700.0
48	ЗДТГ-ын ня-бо С.Ганцож	Цалин илүү олгосон	60,000.0	60,000.0		60,000.0
49	Дашигчилэн Баянсаруул	Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	69,800.0	69,800.0		69,800.0
50	Огиль	Бруцеллез хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	60,000.0	60,000.0		60,000.0
51	Сумын Засаг дарга	Вакцинжуулалтын үйлчилгээний хөлсийг илүү олгосон	58,800.0	58,800.0		58,800.0
52	МЭУТасаг	Эмэгжүүлэлтийн ажлын гүйцэтгэл дутуу, санхүүжилт бүрэн авсан	50,000.0	50,000.0		50,000.0
53	Орхон Орхон-Оч	Бруцеллез тарилга хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	50,950.0	50,950.0		50,950.0
54		Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	32,159,100.0		32,159,100.0	32,159,100.0
55		Бруцеллез хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	769,350.0		769,350.0	769,350.0
56	Хулсан шарга	Бруцеллез хийсэн малын цуваа зөрүүтэй	100,000.0	100,000.0		100,000.0
57	Их мээж хайрхан	Бруцеллез хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	20,000.0	20,000.0		20,000.0
58		Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	105,000.0	105,000.0		105,000.0
59	Сумын Засаг дарга	Вакцинжуулалтын үйлчилгээний хөлсийг илүү олгосон	30,000.0	30,000.0		30,000.0
60	МЭУТасаг	Эмэгжүүлэлтийн ажлын гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгосон	337,800.0		337,800.0	
61	Могод, ММЭ	Бруцеллез хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	617,600.0	617,600.0		
62		Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	23,528,000.0		23,528,000.0	
63	ХДС	Бруцеллез хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	784,700.0		784,700.0	
64		Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	100,000.0	100,000.0		100,000.0
65	МЭУТасаг	Эмэгжүүлэлтийн ажлын гүйцэтгэл дутуу, санхүүжилт бүрэн авсан	48,950.0	48,950.0		48,950.0
66	Сайхан, Улаан сайхан	Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	106,000.0	106,000.0		106,000.0

67	Сумын Засаг даргад	Вакцинжуулалтын үйлчилгээний хөлс авсан малын тоо зөрүүтэй, малын эрүүл мэндийн дэвэрт бичигт хийгээгүй	50,000.0	50,000.0	50,000.0	50,000.0
68	МЭҮТасаг	Эмэгжүүлэлтийн ажлын гүйцэтгэл дутуу, санхүүжилт бүрэн авсан	100,000.0	100,000.0	100,000.0	100,000.0
69	Сэлэнгэ Мөнгөн сүмбэр уул	Бруцеллез хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	50,000.0	50,000.0	50,000.0	50,000.0
70		Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	80,000.0	80,000.0	80,000.0	80,000.0
71	Төшиг Додд нарийн	Бруцеллез хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	30,000.0	30,000.0	30,000.0	30,000.0
72		Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	456,000.0	456,000.0	456,000.0	456,000.0
73	Эрэн шонхор	Бруцеллез хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	142,000.0	142,000.0	142,000.0	142,000.0
74		Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	38,000.0	38,000.0	38,000.0	38,000.0
75	Буурлын хөндий	Бруцеллез хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	366,400.0	366,400.0	366,400.0	366,400.0
76		Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	60,000.0	60,000.0	60,000.0	60,000.0
77	МЭҮТасаг	Эмэгжүүлэлтийн ажлын гүйцэтгэл дутуу, санхүүжилт бүрэн авсан	30,000.0	30,000.0	30,000.0	30,000.0
78	Хишиг-Өндөр Ганнаран	Бруцеллез хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	250,000.0	250,000.0	250,000.0	250,000.0
79		Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	70,000.0	70,000.0	70,000.0	70,000.0
80	МЭҮТасаг	Эмэгжүүлэлтийн ажлын гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгосон	319,700.0	319,700.0	319,700.0	319,700.0
81	Хутаг-Өндөр Эрэн цалам	Бруцеллез тарилга хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	120,000.0	120,000.0	120,000.0	120,000.0
82		Вакцинжуулалт хийсэн малын цуваа зөрүүтэй	80,000.0	80,000.0	80,000.0	80,000.0
83	Асаат баян	Бруцеллезын тарилга хийсэн малын цувааны тоо зөрүүтэй	165,300.0	165,300.0	165,300.0	165,300.0
		Дүн	201,868,238.0	47,042,702.0	154,825,536.0	34,353,450.0
		Говьсүмбэр аймгийн аудитын газар				59,812,486.0
1	Аймгийн ХХААЖДҮГГазар	Хөтөлбөрийн хүрээнд нийлүүлсэн вакцины хадгалах хөрүүр эвдэрсэн	125,021,608.0		125,021,608.0	
2	Аймгийн ХХААЖДҮГГазар	Хөтөлбөрийн хүрээнд олгосон үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	10,673,144.0		10,673,144.0	
3	Аймгийн ХХААЖДҮГГазар	Аймгийн улсын байцаагчийн дүгнэлтээр устгасан вакцины хожирлыг холбогдох байгууллагаар нөхөн төлүүлэх	317,180,800.0		317,180,800.0	
		Дүн	452,875,552.0	-	452,875,552.0	-
		Баянхонгор аймгийн Аудитын газар				
1	Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг 35 аж ахуйн нэгж	Мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг илүү олгосон	57,380,000.0	57,380,000.0		
2	Аймгийн ХХААЖДҮГГазар	Бэлчээрийн хортон мэрэгч устгах ажлын санхүүжилтийг зориулт бусаар зарцуулсан	1,500,000.0	1,500,000.0		
3	Хувийн хэвшлийн ШИДЗ, Дөвөнтийн нөмөр, Буянт хөвөөр, Говийн хишиг ХХК	Аж ахуйн нэгжүүдэд илүү олгосон вакцинжуулалтын үйлчилгээний хөлсийг илүү олгосон	12,443,300.0	12,443,300.0		
4	ХХААЖДҮГГазар, бүх сумын ЗДТГазар	Хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	59,048,500.0		59,048,500.0	59,048,500.0
		Дүн	130,371,800.0	71,323,300.0	59,048,500.0	59,048,500.0
		Говь-Алтай аймгийн Аудитын газар				
1	ХХААЖДҮГ, Мал үржлийн алба	Малын эмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийн ажлыг бүрэн хийгдээгүй байхад үйлчилгээний хөлсийг олгосон	15,400,000.0	15,400,000.0		
2	ХХААЖДҮГ, Мал үржлийн алба	Хөтөлбөрийн хүрээнд сумдын МАА-н чиглэлийн хоршоо, сумдад үйл ажиллагаа явуулж буй хоршодын түүхийг эд бэлтгэлийн агуулах шинээр барих, сэргээн засварлахад эзэл олгосон боловч түүний эргэн төлөлт хугацаандаа хийгдсэн эсэх нь тодорхойгүй	296,500,000.0		296,500,000.0	296,500,000.0
3	ХХААЖДҮГ, Мал үржлийн алба, сумдын МЭҮТ	Үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	36,000,000.0		36,000,000.0	36,000,000.0
		Дүн	347,900,000.0	15,400,000.0	332,500,000.0	332,500,000.0
		Орхон аймгийн Аудитын газар				
1	ХХААЖДҮГ-ын дарга Т.Отгон, нягтлан бодогч Ө.Жаргалсайхан	Нөхөн олговрын малын дундаж ханшийн зөрүүг төлүүлэх	1,016,000.0	1,016,000.0		
2	ХХААЖДҮГ-ын дарга Т.Отгон, нягтлан бодогч Ө.Жаргалсайхан	Малын эмэгжүүлэлтийн үлдэгдлийг төлүүлэх	1,200,000.0	1,200,000.0		
3	ХХААЖДҮГ-ын дарга Т.Отгон, нягтлан бодогч Ө.Жаргалсайхан	Нийлүүлэгдээгүй вакцины үнийг төлүүлэх	15,500,000.0	15,500,000.0		
		Дүн	17,716,000.0	17,716,000.0		

Баян-Өлгийн аймгийн Аудитын газар									
1	Бутаг сумын Засаг дарга Х. Эржанат		854,900.0				854,900.0		854,900.0
2	Толбо сумын Засаг дарга Х. Эржанат		1,004,900.0				1,004,900.0		1,004,900.0
3	Булган сумын Засаг дарга Х. Эржанат	Үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	1,734,300.0				1,734,300.0		1,734,300.0
4	Ногоон нуур сумын Засаг дарга Х. Эржанат		1,200,000.0				1,200,000.0		1,200,000.0
		Дүн	4,794,100.0				4,794,100.0		4,794,100.0
Архангай аймгийн Аудитын газар									
1	ХХААХДҮГ-ын дарга Ч.Баасанжав, нягтлан бодогч Ө.Жавзанпама	Үхэр, хонь, ямаанд хийх ивөөмөх төрийг хийгээгүй байхад үйлчилгээний хөлсийг олгосон	13,850,000.0				13,850,000.0		
2	Цагаансүмбэр ХХК-ны захирал	Гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй тул алданги тооцсон	1,518,660.0				1,518,660.0		
3	Цагаансүмбэр ХХК-ны захирал	Гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй тул алданги тооцсон	3,587,913.0				3,587,913.0		
4	ХХААХДҮГ-ын дарга Ч.Баасанжав	Үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	277,878,900.0				277,878,900.0		277,878,900.0
		Дүн	296,835,473.0				296,835,473.0		277,878,900.0
Завхан аймгийн Аудитын газар									
1	ХХААХДҮГ-ын дарга Ч.Баасанжав, нягтлан бодогч Ө.Жавзанпама	Бруцеллёзын үйлчилгээний хөлсийг илүү, дутуу олгосон	10,654,200.0				10,654,200.0		10,654,200.0
2		Бруцеллёзын үйлчилгээний хөлсийг зориулалт бусаар зарцуулсан	4,400,000.0				4,400,000.0		4,400,000.0
3	13 сумын Засаг дарга	Томилолтын мөнгийг илүү олгосон	3,849,200.0				3,849,200.0		
		Дүн	18,903,400.0				18,903,400.0		15,054,200.0
Ховд аймгийн Аудитын газар									
1	ХХААХДҮГ-ын дарга З.Луусан, нягтлан бодогч Ж.Болормаа	Вакцины үнэ төлүүлэх тухай	1,801,957.0				1,801,957.0		
2	ХХААХДҮГ-ын дарга Г.Гончигсүрэн, нягтлан бодогч Ц.Нямсүрэн	Илүү олгосон ажлын хөлсийг төлүүлэх тухай	7,167,300.0				7,167,300.0		
3	Эрдэнэбүрэн сумын Засаг дарга Ц.Отгонбаяр, Төрийн сангийн төлөөлөгч А.Бадамсүрэн	МЗУСАХ-ний төсвийн хэмнэлтийг төлүүлэх тухай	7,271,400.0				7,271,400.0		
4	Дуут сумын Засаг дарга С.Түмэнжаргал, Төрийн сангийн төлөөлөгч А.Оюунбилэг	Хонины ноос, тэмээний ноосны илүү олгосон урамшуулал төлүүлэх тухай	5,087,000.0				5,087,000.0		
5	Дөргөн сумын Засаг даргын ТГ-ын дарга Ж.Батбаяр, Төрийн сангийн төлөөлөгч Э.Анхцэцэг	Хонины ноос, тэмээний ноосны илүү олгосон урамшуулал төлүүлэх тухай	5,495,615.0				5,495,615.0		
6	Эрдэнэбүрэн сумын Засаг дарга Ц.Отгонбаяр, Төрийн сангийн төлөөлөгч А.Бадамсүрэн	Хонины ноос, тэмээний ноосны илүү олгосон урамшуулал төлүүлэх тухай	1,361,700.0				1,361,700.0		
7	Дөргөн сумын Засаг даргын ТГ-ын дарга Ж.Батбаяр	Зөрчил арилгуулах тухай	1,551,000.0				1,551,000.0		1,551,000.0
		Дүн	29,736,972.0				29,736,972.0		1,551,000.0
Дархан-Уул аймгийн Аудитын газар									
1	Аймгийн ХХААХДҮГ газар	Бруцеллёзын тарилгын үйлчилгээний хөлсийг илүү олгосон	5,321,439.0				5,321,439.0		
		Дүн	5,321,439.0				5,321,439.0		
Үндэсний аудитын газар									
1	УХАА-ны Төрийн нэрийн бичгийн дарга Х.Золжаргал	Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан	217,644,000.0				217,644,000.0		
		НИЙТ ДҮН	217,644,000.0				217,644,000.0		
			1,723,966,974.0				207,795,186.0		34,363,450.0
									750,639,186.0